



IP Утас ашиглах заавар

(Grandstream DP720 гар / DP750 станц)





1. Утсаа унтрааж асаах болон чухал товчлууруудын заавар


Асаах: LCD дэлгэц асах хүртэл  Power товчлуур дээр удаан дарх,

Унтраах: Утсаа унтраах бол  Power товчлуурыг удаан дарна.

Дууг хаах: Од товч дээр 3сек дарж хонхны аяыг хаана. Дуудлага ирэх үед утас дуугарахгүй болно.


Идэвхгүй горим:  товчлуур дээр 3сек дарж **Do Not Disturb** = DND горим буюу дуудлага авахгүй

горимд орно. Энэ үед дэлгэц дээр  тэмдэглэгээ гарч ирнэ. Энэ үед залгасан талд завгүй гэсэн дохио өгнө. Идэвхгүй болгох бол  товчлуур дээр 3сек

дарна. Идэвхгүй болсон бол дэлгэц дээр  тус тэмдэглэгээ байхгүй болсон байна.


2. DP720-аас DP750-т бүртгүүлэх

DP750 Суурь станц дээр байгаа Радио товчлуурыг


 7 секунд турш дарснаар холбогдох процесс эхэлнэ. Эсвэл web хөтөч ашиглан DP750 админ эрхээр нэвтрээд тохиргоо хийх боломжтой.

DP720 дээр, **Menu > Settings > Registration > Register** тохиргоог хийх үед DP750 Радио дүрс анивчина. *Тэмдэглэл: "Subscribe" товчлуур нь DP720-ийг ямар ч DP750 суурь станцад бүртгүүлээгүй тохиолдолд л гарч ирнэ.*




3. Суурь станцын IP хаяг шалгах

DP720 гараас **Menu** цэс рүү орохын тулд  (голын товч) дарна. Курсорыг (Дээш, Доош, Баруун, Зүүн) **Status** цэс дээр аваачиж **"Select"** (Зүүн дээр) сонгоод **Base status** дээр **OK** (Зүүн дээр) товчийг дарна. Курсорыг ашиглан доош гүйлгээд, **DP750** станцын IP хаягийг үзэх боломжтой.



4. Утасны цоожийг тайлах, цоожлох

 товчлуур дээр 2 секунд орчим дарж цоожлох болон тайлах үйлдлийг хийнэ..


5. Утасны нэрийг өөрчлөх

Menu цэс рүү орохын  тулд голын (товч) дарна. Курсороо ашиглан **Settings**  цэсийг сонгоно. Дараа нь **Handset Name** цэсийг **"Select"**  ашиглан сонгоно. Хүссэн нэрийг оруулаад **"Rename"** (зүүн талын товчлуур) товчийг дарахад DP720 нь нэрийг өөрчлөх ажиллагаа амжилттай болсон гэсэн мессежийг харуулна..



6. Үндсэн Пин код өөрчлөх

Menu цэс рүү орохын  тулд голын (товч) дарна. Курсороо ашиглан **Settings**  цэсийг сонгоно. **"Select"** хийж сонгоод **Change Base Pin**-ийг сонгоно. Ашиглах кодыг оруулна уу (Анхдагч код нь **0000**), таныг нууц үгээ оруулах шинэ цонх гарч ирэх бөгөөд **"Save"** (зүүн талын товчлуур) товчийг дарахад шинэ PIN амжилттай хадгалагдсаныг баталгаажуулах мэдэгдлийг харуулна.




7. Утасны хэлийг өөрчлөх

Settings  цэсийг сонгоно. **"Select"** хийж сонгоод **Phone language** цэс рүү орж өөрийн хүссэн хэлийг сонгоод **"Yes"** (зүүн дээр) товчийг дарна.


8. Он сар өдөр тохируулах

Settings  цэсийг сонгоно. **"Select"** хийж сонгоод **Date and time** цэс рүү орно.  товчлуурыг ашиглаж цагийн формат, **Set** дарж баталгаажуулна.



9. Дуудлага хийх

Залгах дугаараа цуглуулаад  дарж залгана. Хэрэв чанга яригчаар ярих бол  дарна. Дуудлага дуусгах бол  дарна.

10. Ярианы шугам сонгох

Хэрэв утас дээр 1-с олон дугаартай бол гарах дуудлагын дугаарын сонгох боломжтой. Хэрэв ганц дугаар байгаа бол энэ боломжгүй. Залгах дугаараа цуглуулаад **Залгах** "зүүн дээд" товчийг  дарснаар боломжит гарах шугамууд гарч ирнэ. Хүссэн шугамаа сонгоход шууд дуудна.

11. Дуудлага авах

Дуудлагад хариулахдаа  дарах эсвэл  дарж чанга яригчаар хүлээн авах боломжтой.


12. Дуудлага шилжүүлэх

Апра-1: Дуудлагыг хүлээн авсан үед шилжүүлэхдээ **Option** цэсийг сонгож шилжүүлэх дугаараа оруулаад **Transfer** товчийг дарснаар дуудлага автоматаар шилжинэ. Хүлээн авагч талд залгаж байгаа хүний дугаар харагдана.

Апра-2: Дуудлагыг хүлээн авсан үед шилжүүлэхдээ **Option** цэсийг сонгож **New call** сонгоод дугаараа оруулаад **Transfer** товчийг дарснаар дуудлага автоматаар шилжинэ. Хүлээн авагч талд шилжүүлсэн хүний дугаар харагдана.

13. Админ тохиргоо

DP750 станц нь вэб интерфейс дэмждэг тул админ нэр, нууц үгээр нэвтрэн орж дугаарын болон дуудлагын ая, системийн тохиргоог хийх боломжтой.



DP720 Цэсний бүтэц